



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: ainurmarkh@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	16
3.1 Ерөнхий зүйл.....	16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Материаллаг байдал	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт.....	20
Байхгүй	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
Р.ХУАТХАН ТАНАА

2022.02.15 № 53
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

СХДАА-Дүгнэлт

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



СХДАА-Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>358,501.40</u>	<u>770,000.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.40	0.40
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.40	0.40
31110	Төгрөг	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	0.40	0.40
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
33400	Зээлийн хүүгийн авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	358,501.00	770,000.00
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
35130	Эм боох материал	-	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	Хангамжийн материал	358,501.00	770,000.00
35410	Бичиг хэргийн материал	62,500.00	609,000.00
35420	Аж ахуйн материал	-	-
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	296,001.00	161,000.00
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,728,664.41</u>	<u>5,989,767.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,728,664.41	5,989,767.55
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	7,728,664.41	5,989,767.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,360,800.00	11,360,800.00

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,972,829.00)	(8,428,045.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,625,433.00	4,735,433.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,284,739.59)	(1,678,419.51)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	-
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>8,087,165.81</u>	<u>6,759,767.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,087,165.72</u>	<u>6,759,767.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,087,165.72	6,759,767.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн	-	-
51102	- хувийн	-	-
51103	- хувьцаат	-	-
51104	Халаасны хувьцаа	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	8,087,165.72	6,759,767.95
51210	Өмнөх үеийн үр дүн	8,087,165.72	8,087,165.72
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,327,397.77)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,087,165.72</u>	<u>6,759,767.95</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	148,387,704.00	175,134,296.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	148,387,704.00	175,134,296.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,353,000.00	-

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	2,353,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,663,304.00	50,123,896.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,663,304.00	50,123,896.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,371,400.00	125,010,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,371,400.00	125,010,400.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	-	-
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	-
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	-
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	148,286,379.90	176,461,693.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	148,286,379.90	176,461,693.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,648,672.39	126,094,747.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,802,226.49	102,813,700.00
210101	Үндсэн цалин	93,802,226.49	70,589,300.00
210102	Нэмэгдэл	-	30,068,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,156,200.00
210104	Урамшуулал	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,444,279.00	12,753,900.00
210201	Тэтгэврийн даатгал	7,782,107.16	8,869,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	915,542.96	971,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,435.97	776,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	183,108.99	194,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,831,083.92	1,942,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210301	Гэрэл, цахилгаан	-	-
210302	Түлш, халаалт	-	-
210303	Цэвэр, бохир ус	-	-
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	2,911,691.00	3,605,901.00
210401	Бичиг хэрэг	990,900.00	1,264,400.00
210402	Тээвэр, шатахуун	840,500.00	1,363,600.00

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,291.00	762,200.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	182,201.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	33,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	4,175,500.00	3,714,950.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	4,175,500.00	3,714,950.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	685,100.00	737,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,100.00	297,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234,000.00	289,500.00
210807	Газрын төлбөр	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,629,875.90	2,468,896.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	266,700.00	620,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,363,175.90	1,848,896.77
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,637,707.51	50,366,946.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	974,403.51	243,050.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	974,403.51	243,050.00
213304	Хөрөнгийн	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,663,304.00	50,123,896.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,663,304.00	50,123,896.00
213404	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	101,324.10	(1,327,397.77)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	101,324.10	(1,327,397.77)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			7,985,841.62	7,985,841.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	7,985,841.62	7,985,841.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			101,324.10	101,324.10
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,087,165.72	8,087,165.72
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,087,165.72	8,087,165.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,087,165.72	8,087,165.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-1,327,397.77	-1,327,397.77
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	6,759,767.95	6,759,767.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	146,034,704.00	175,134,296.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,034,704.00	175,134,296.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
131005	Хөрөнгийн санхүүжилт		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,663,304.00	50,123,896.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,663,304.00	50,123,896.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,371,400.00	125,010,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,371,400.00	125,010,400.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>146,034,704.00</u>	<u>175,024,296.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>146,034,704.00</u>	<u>175,024,296.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>113,396,996.49</u>	<u>124,657,350.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,275,605.49	102,813,700.00
210101	Үндсэн цалин	66,795,955.49	70,589,300.00
210102	Нэмэгдэл	24,353,200.00	30,068,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,126,450.00	2,156,200.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,970,900.00	12,753,900.00
210201	Тэтгэврийн даатгал	8,423,900.00	8,869,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	886,800.00	971,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	709,400.00	776,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	177,300.00	194,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,773,500.00	1,942,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт		
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	2,974,191.00	3,854,900.00
210401	Бичиг хэрэг	1,053,400.00	1,443,100.00
210402	Тээвэр, шатахуун	840,500.00	1,649,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,291.00	762,200.00

210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2107	Томилолт, зочны зардал	4,175,500.00	3,714,950.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,175,500.00	3,714,950.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	685,100.00	899,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,100.00	370,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	234,000.00	379,500.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315,700.00	620,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,700.00	620,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,637,707.51	50,366,946.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	974,403.51	243,050.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	974,403.51	243,050.00
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,663,304.00	50,123,896.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,663,304.00	50,123,896.00
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>110,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	110,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	110,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	110,000.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		110,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(110,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,010,400.00	124,767,350.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,010,400.00	124,767,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,010,400.00	124,767,350.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,813,700.00	102,813,700.00
210101	Үндсэн цалин	70,589,300.00	70,589,300.00
210102	Нэмэгдэл	30,068,200.00	30,068,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,156,200.00	2,156,200.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,753,900.00	12,753,900.00
210201	Тэтгэврийн даатгал	8,869,900.00	8,869,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	971,000.00	971,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	776,800.00	776,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	194,200.00	194,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,942,000.00	1,942,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт		
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	3,854,900.00	3,854,900.00
210401	Бичиг хэрэг	1,443,100.00	1,443,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,649,600.00	1,649,600.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	762,200.00	762,200.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2107	Томилолт, зочны зардал	3,958,000.00	3,714,950.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	3,958,000.00	3,714,950.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	899,900.00	899,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370,400.00	370,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,500.00	379,500.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	730,000.00	730,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	730,000.00	730,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,010,400.00	124,767,350.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	125,010,400.00	124,767,350.00
132001	Орон нутгийн төсвөөс	125,010,400.00	124,767,350.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7.00	7.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00

620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7.00	7.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(0.40)
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,663,304.00	50,123,896.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,663,304.00	50,123,896.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,663,304.00	50,123,896.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,663,304.00	50,123,896.40
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,663,304.00	50,123,896.40
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	31,663,304.00	50,123,896.40
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,663,304.00	50,123,896.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,663,304.00	50,123,896.40

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,663,304.00	50,123,896.40
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 148.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1046.9 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	-	-
Урьдчилгаа			
Бараа материал	358.1	770.0	411.9
Үндсэн хөрөнгө	7728.7	5989.8	-1738.9
Нийт хөрөнгө	8087.2	6759.8	-1327.4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8087.2	6759.8	-1327.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8087.2	6759.8	-1327.4

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна. Тайлант оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлаас 0.2 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны

орлогоос 50.1 сая төгрөгийн, нийт 50.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой авлага үүсгэж ажиллаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалын зарцуулаагүй үлдэгдэл нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй он удаан жил болсон бараа материалын байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл бичиг хэргийн материалын үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материалын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.7 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан. Акталсан болон шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй байна. Тайлант онд ашиглаж буй үндсэн хөрөнгөд нийт 1.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд үйл ажиллагаатай холбоотой өр үүсгээгүй байна. Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 1.3 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26.7 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 10.6 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 18.5 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Цалин болон НДШ-ийн зардлыг өнгөрсөн оны төсвөөс 9.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бусад зардлуудыг 0.2-2.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Нийт зардал өмнөх оноос 286.2 сая төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, хангамж, бараа материалын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 1.3 сая төгрөг байна. Өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 16 дугаар тогтоолоор тус газрын анхны төсвийг 125.0 сая төгрөгөөр, төсвийн тодотголоор 125.0 сая төгрөгөөр баталж, анх баталсан дүнгээс өөрчлөлт оруулаагүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 125.0 сая төгрөгийн төсөв баталснаас 125.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 125.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 124.8 сая төгрөгийг зарцуулжээ.

Үндсэн санхүүжилтээс 0.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд: томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 124.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь тайлант оны батлагдсан төсвөөс томилолтын зардлыг 0.2 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснийг орлогод авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого /баримтын шалгалтын актыг төлбөр/-оос 50.1 сая төгрөгийг нэмэлт дансанд төвлөрүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 117 мэдээллийг ил тод байршуулсан ба 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, цалингаас бусад зарлагын гүйлгээ гараагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг хугацаанд ирүүлсэн, зөрчлийг давтан гаргаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх эсвэл анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үйл ажиллагааны зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажилчдын амралтын цалинг холбогдох журмын дагуу тооцож олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 3 дугаар зүйлийг мөрдлөг болгон, амралтын цалинг журмын дагуу тооцож олгох.

1.2. Илрүүлэлт:

Ажилчид хөдөө сумдад томилолтоор явж 1.1 сая төгрөгийн байрны мөнгийг авч байсан боловч үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэн цахим төлбөрийн баримт гаргуулахгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д “ Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ”, Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “ Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийлэг хэрэглэгдэх анхан шатны баримтыг нөхөх нийтлэг заавар”-ын 6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	СХДАА	0	0	0	0	0	0	0	0	2	1.1